

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/2/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 260512 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитор:М. Пагамдулам Утас: 261740 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn</p> <p>“Мэдээлэл Аудит” ХХК-ийн Захирал Д.Товуудорж Утас:70159511, 99049511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com</p>
-----------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/811
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй дараах алдаа, зөрчил нь тогтоосон 276.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Олон жил болсон эзэн холбогдогч тодорхойгүй 142.3 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, ТУЗ-д танилцуулаагүй;
- Авлагын 250.4 сая төгрөгийн үлдэгдлийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;

зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ болон Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ-ыг нийлүүлэн Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК болгон өөрчлөн нэгтгэснээр шилжиж ирсэн 2013 онд үүссэн 392.7 сая төгрөгийн авлага, Эгийн голын усан цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн судалгаа хийхтэй холбоотойгоор 1992 онд үүссэн 3,731.1 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Эрчим хүчний сайдын төсвийн багцын 42 төсөл, арга хэмжээний 65 барилга, угсралтын ажлаас дуусаагүй 54 ажил, Мянганы сорилын сангийн хэрэгжилтээр 9 барилга, угсралтын ажил, Байгаль орчин аялал жуулчлалын яамны орчны бохирдлыг бууруулах төслийн хүрээнд хэрэгжиж буй 4 барилга, угсралтын ажил, гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50МВт-аар өргөтгөх төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажил, Амгалан дулааны станцын өргөтгөл Улаанбаатар хотын зүүн бүсийн дулааны хэрэглээний өсөлтийг хангах төслийн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 48 зорилтын хүрээнд 290 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийг 100.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,287,543,755.91	4,813,676,309.33
1.1.02	Дансны авлага	1,124,159,873.42	1,116,704,675.65
1.1.04	Бусад авлага	14,760.00	1,522,313.78
1.1.06	Бараа материал	369,264,286.67	382,723,355.76
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,547,012.14	47,779,795.15
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,791,529,688.14	6,362,406,449.67
1.2.01	Үндсэн хөрөнгө	8,884,546,138.34	8,484,242,674.55
1.2.02	Биет бус хөрөнгө	15,346,273.97	62,719,758.55
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	12,884,359,100.00	12,884,359,100.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	21,784,251,512.31	21,431,321,533.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,575,781,200.45	27,793,727,982.77
2.1.1.01	Дансны өглөг	433,938,361.04	3,972,696,652.71
2.1.1.02	Цалингийн өглөг	2,113,441.87	-
2.1.1.03	Татварын өр	2,338,462,257.50	711,237,155.03
2.1.1.04	НДШ-ийн өглөг	183,183,571.03	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	493,177,709.89	1,432,005,578.01
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,450,875,341.33	6,115,939,385.75
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,731,110,140.00	3,731,110,140.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,181,985,481.33	9,847,049,525.75
2.3.01	Өмч: - төрийн	3,300,991,177.74	3,300,991,177.74
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,019,474,302.61	3,019,474,302.61
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	14,027,740,234.70	14,279,770,721.57
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(2,954,409,995.93)	(2,653,557,744.89)
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,393,795,719.12	17,946,678,457.03
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,575,781,200.45	27,793,727,982.77

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,530,111,933.07	7,470,552,078.12
2	Борлуулалтын өртөг	4,165,616.29	42,700,225.89
3	Нийт ашиг(алдагдал)	1,525,946,316.78	7,427,851,852.23
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		112,017,267.63
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,446,440,263.01	7,168,947,212.13
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		30,803,382.27
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	6,706,461.15	(5,838,246.54)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(20,883,333.50)	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	65,329,181.42	334,280,278.92
19	Орлогын татварын зардал	6,532,918.14	33,428,027.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	58,796,263.28	300,852,251.03
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	58,796,263.28	300,852,251.03
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 09-р сарын 16-ны үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	12,796,181,934.70	(3,013,206,259.22)	16,103,441,155.83
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	12,796,181,934.70	(3,013,206,259.22)	16,103,441,155.83
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				58,796,263.29	58,796,263.29
Өмчид гарсан өөрчлөлт			1,231,558,300.00		1,231,558,300.00
2022 оны 12 сарын 31- ээр үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	14,027,740,234.70	(2,954,409,995.93)	17,393,795,719.12
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	14,027,740,234.70	(2,954,409,995.93)	17,393,795,719.12
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				300,852,251.04	300,852,251.04
Өмчид гарсан өөрчлөлт			252,030,486.87		252,030,486.87
2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	3,300,991,177.74	3,019,474,302.61	14,279,770,721.57	(2,653,557,744.89)	17,946,678,457.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,035,899,263.35	9,235,263,246.86
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,024,016,414.00	9,174,703,344.88
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	11,882,849.35	60,559,901.98
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,006,117,552.91	5,588,934,166.78
1.2.1	Ажиллагчдад төлсөн	495,213,048.23	1,965,875,892.32
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	153,036,096.02	809,340,818.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	31,898,895.00	258,753,097.10
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	16,115,415.84	55,268,043.84
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,626,931.00	59,128,700.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		891,408.46
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		365,522,383.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		27,568,992.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	290,227,166.82	2,046,584,831.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,029,781,710.44	3,646,329,080.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		112,017,267.63
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		112,017,267.63
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	202,815,644.29
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	193,913,609.09
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		8,902,035.20
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(90,798,376.66)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		29,398,150.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		29,398,150.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(29,398,150.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,029,781,710.44	3,526,132,553.42
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	257,762,045.46	1,287,543,755.91
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,287,543,755.91	4,813,676,309.33

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт орлого	мян/төг	1,536,818.4	7,562,861.7	7,582,569.3	19,707.7	0.3
Захиалагчийн техник хяналтын орлого	мян/төг	777,436.7	3,032,517.8	2,549,933.3	(482,584.5)	(18.9)
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	мян/төг	758,086.7	1,796,041.1	2,363,504.1	567,463.0	24.0
Гадаад зээл тусламж болон хувийн хөрөнгөөр	мян/төг	19,350.0	1,236,476.7	186,429.2	(1,050,047.5)	(563.2)
Зураг төсөл магадлалын орлого	мян/төг	327,723.0	594,000.0	656,488.0	62,488.0	9.5
Сэргээгдэх эрчим хүчний орлого	мян/төг	45,887.0	812,490.3	220,720.0	(591,770.3)	(268.1)
Лабораторийн үйл ажиллагааны орлого	мян/төг	83,624.1	443,300.0	485,523.3	42,223.3	8.7
Тусгай зөвшөөрлийн орлого	мян/төг	103,700.0	1,345,745.9	1,666,931.9	321,186.0	19.3
Техникийн нөхцөлийн орлого	мян/төг	34,240.9	501,931.3	1,011,148.2	509,216.9	50.4
Сургалтын орлого	мян/төг	125,015.6	508,976.5	654,465.1	145,488.6	22.2
Түрээсийн орлого	мян/төг	23,325.5	87,600.0	100,517.7	12,917.7	12.9
Хүүгийн орлого	мян/төг		89,866.3	112,017.3	22,151.0	19.8
Бусад орлого /Хэвлэх цех, ҮҮА /	мян/төг	15,865.7	146,433.5	124,824.6	(21,609.0)	(17.3)
Нийт зардал	мян/төг	1,471,489.2	7,097,269.7	7,248,289.1	151,019.3	2.1
Татварын өмнөх ашиг (алдагдал)	мян/төг	65,329.2	465,591.9	334,280.3	(131,311.6)	(39.3)
Цэвэр ашиг (алдагдал)	мян/төг	58,796.3	419,032.7	300,852.2	(118,180.5)	(39.3)
Нийт авлага	мян/төг	1,124,174.6	1,086,531.6	1,118,227.0	31,695.4	2.8
Үүнээс: Найдваргүй	мян/төг		392,733.6	416,828.4	24,094.7	5.8
Нийт өр төлбөр	мян/төг	7,181,985.5	6,258,210.6	6,341,423.6	83,213.0	1.3
Богино хугацаат өр төлбөр	мян/төг	3,450,875.3	2,527,100.5	2,657,415.5	130,315.0	4.9
Урт хугацаат өр төлбөр	мян/төг	3,731,110.1	3,731,110.1	3,731,110.1	-	-
Нийт ажиллагсдын тоо	хүн	94.0	94.0	77.0	(17.0)	(22.1)
Нийт цалингийн сан	мян/төг	554,444.0	2,704,701.0	2,573,850.1	(130,851.0)	(5.1)
Нэг ажилтны дундаж цалин	мян/төг	1,966.1	2,397.8	2,540.5	142.7	5.6
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	0.9	1.0	0.0	1.8
Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	мян/төг	-	727,799.0	555,158.3	(172,640.7)	(31.1)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 398,649.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 5,916.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 392,733.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тус компанийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ-ыг 2012 онд үүсгэн байгуулахад эхлэлтийн баланст тусгасан Эгийн голын усан цахилгаан станц барих төслийн хүрээнд хэрэгжсэн 1152-MON(SF) тоот Эгийн голын УЦС барих дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл 3,731.1 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй, Эгийн голын усан цахилгаан станцын Техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгааны 46 боть хэвлэмэл материалыг холбогдох байгууллагад хандаж шилжүүлээгүй байна	1	-					1	-				
2	Байгууллагаас авах 250.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна	1	392,733.6			1	392,733.6						
3	Орон нутгийн томилолтоор ажилласан ажилчдад албан томилолтын хугацаанд 5.9 сая төгрөгийн хоол, унааны мөнгө давхардуулан олгосон	1	5,916.0	1	5,916.0								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/89 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба шинэчлэгдсэн стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн өөрчлөлтийг тухай бүрд нь тусгаагүй байна	1						1					
Дүн		4	398,649.6	1	5,916.0	1	392,733.6	2					

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<i>Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>									
Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих нийт 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1							1	
Нийт дүн	1							1	